



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/30/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Болдбаатар
Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	2
1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.6.1 Төсвийн төлөвлөлт	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.6.3 Нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Албан шаардлага	16
4.2 Зөвлөмж	16
1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Салбар. ал. дг. № 17
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН
ГАЗРЫН ДАРГА М.МОЛОРЧИМЭГ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>174,647,881.01</u>	<u>169,317,147.96</u>
34	УРЬДЧИЛГАА	-	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	174,647,881.01	162,117,147.96
351	Түүхий эд материал	166,509,644.41	153,408,245.96
35130	Эм боох материал	166,509,644.41	153,408,245.96
354	Хангамжийн материал	6,683,236.60	7,253,902.00
35410	Бичиг хэргийн материал	924,490.00	812,640.00
35420	Аж ахуйн материал	5,005,505.00	5,941,262.00
35440	Түлш, шатах тослох материал	553,241.60	-
35470	Бусад хангамжийн материал	200,000.00	500,000.00
35600	Мал амьтад	1,455,000.00	1,455,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>534,968,531.08</u>	<u>532,152,991.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	534,968,531.08	532,152,991.82
392	Биет хөрөнгө	391,348,531.08	386,132,991.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	86,266,916.00	86,266,916.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,161,910.97)	(12,962,086.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	231,912,029.67	231,912,029.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	(135,733,456.09)	(144,229,888.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	840,355,614.01	504,125,663.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	(644,151,354.40)	(301,014,292.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,847,027.50	48,252,607.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,988,417.90)	(26,988,790.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,850,000.00	1,850,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(847,916.74)	(1,079,166.76)
393	Биет бус хөрөнгө	143,620,000.00	146,020,000.00
39301	Програм хангамж	1,180,000.00	3,580,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,180,000.00)	(1,180,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	143,620,000.00	143,620,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>709,616,412.09</u>	<u>701,470,139.79</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,850,140.00</u>	<u>(0.00)</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,850,140.00	(0.00)
413	Өглөг	3,850,140.00	(0.00)
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,850,140.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>705,766,272.09</u>	<u>701,470,139.79</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	705,766,272.09	701,470,139.79
512	Хуримтлагдсан үр дүн	661,815,028.29	657,518,895.99
51210	Өмнөх үеийн үр дүн	575,479,321.99	661,815,028.29
51220	Тайлант үеийн үр дүн	86,335,706.30	(4,296,132.30)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,951,243.80	43,951,243.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>709,616,412.09</u>	<u>701,470,139.79</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,753,675,379.34	3,170,822,919.22
12.00	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,138,452,430.34	1,363,564,669.22
120.00	Нийтлэг татварын бус орлого	4,138,452,430.34	1,363,564,669.22
120,004.00	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,138,452,430.34	1,363,564,669.22
1,200,041.00	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,985,200.00	28,000.00
1,200,045.00	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,135,467,230.34	1,363,536,669.22
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,615,222,949.00	1,807,258,250.00
1,310.00	Улсын төвлөрсөн төсвөөс	605,083,300.00	906,939,600.00
131,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	605,083,300.00	906,939,600.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,010,139,649.00	900,318,650.00
131,103.00	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	121,469,489.00	34,502,100.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	888,670,160.00	865,816,550.00
2.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,667,339,673.04	3,235,551,643.44
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	5,667,339,673.04	3,235,551,643.44
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,657,109,252.40	3,206,905,164.39
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	126,395,300.00	473,689,714.70
210,101.00	Үндсэн цалин	82,201,100.00	390,178,059.75
210,102.00	Нэмэгдэл	40,570,200.00	68,887,664.26
210,103.00	Унаа хоолны хөнгөлөлт	3,624,000.00	14,623,990.69
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,063,600.00	63,777,102.54
210,201.00	Тэтгэврийн даатгал	12,007,600.00	44,680,402.54
210,202.00	Тэтгэмжийн даатгал	1,264,000.00	4,774,200.00
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	1,011,100.00	3,819,300.00
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	252,900.00	954,900.00
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	2,528,000.00	9,548,300.00
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,129,513.00	13,017,878.31
210,301.00	Гэрэл, цахилгаан	8,703,017.00	9,189,999.01
210,302.00	Түлш, халаалт	2,149,996.00	3,586,779.30
210,303.00	Цэвэр, бохир ус	276,500.00	241,100.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	47,979,380.40	65,767,760.70
210,401.00	Бичиг хэрэг	8,799,255.00	4,564,150.00
210,402.00	Тээвэр, шатахуун	32,177,862.40	15,966,732.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,212,080.00	3,487,700.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	864,000.00	711,600.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,926,183.00	526,650.00
210,409.00	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/		40,510,928.70
2,105.00	Нормативт зардал	3,988,986,000.37	1,318,618,155.31
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,988,986,000.37	1,318,618,155.31
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	3,835,890.00	4,271,593.00
210,604.00	Урсгал засвар	3,835,890.00	4,271,593.00
2,107.00	Томилолт, зочны зардал	19,967,960.00	17,838,400.00
210,702.00	Дотоод албан томилолт	19,967,960.00	17,838,400.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,300,323,238.36	1,132,819,855.00

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,298,580,708.36	1,127,752,380.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	
210,803.00	Даатгалын үйлчилгээ	577,530.00	632,655.00
210,804.00	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	549,820.00
210,805.00	Тээврийн хэрэгслийн оношилогоо	265,000.00	143,000.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		3,600,000.00
210,807.00	Газрын төлбөр	-	142,000.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	141,428,370.27	117,104,704.83
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	66,519,442.00	8,979,600.00
210,903.00	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,908,928.27	108,125,104.83
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,230,420.64	28,646,479.05
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	750,000.00	27,635,501.00
213,207.00	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		26,839,500.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750,000.00	796,001.00
2,133.00	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,480,420.64	1,010,978.05
213,303.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,480,420.64	1,010,978.05
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>86,335,706.30</u>	<u>(64,728,724.22)</u>
5.00	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>86,335,706.30</u>	<u>(64,728,724.22)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		43,951,243.80	575,479,321.99	0.00	619,430,565.79
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	43,951,243.80	575,479,321.99	0.00	619,430,565.79
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	86,335,706.30	0.00	86,335,706.30
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	43,951,243.80	661,815,028.29	0.00	705,766,272.09
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	43,951,243.80	661,815,028.29	0.00	705,766,272.09
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	43,951,243.80	661,815,028.29	0.00	705,766,272.09
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-64,728,724.22	0.00	-64,728,724.22
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	43,951,243.80	597,086,304.07	0.00	641,037,547.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,618,452,149.00</u>	<u>1,807,286,250.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,985,200.00	28,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,985,200.00	28,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,985,200.00	28,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,985,200.00	28,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,615,466,949.00	1,807,258,250.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	605,083,300.00	906,939,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	605,083,300.00	906,939,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,010,383,649.00	900,318,650.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	121,469,489.00	34,502,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	888,914,160.00	865,816,550.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,611,292,149.00</u>	<u>1,793,586,250.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,611,292,149.00	1,793,586,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,600,754,228.36	1,764,939,770.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	126,395,300.00	477,318,159.86
210101	Үндсэн цалин	84,651,100.00	391,696,702.75
210102	Нэмэгдэл	38,120,200.00	70,002,266.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,624,000.00	15,619,190.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,063,600.00	63,998,797.38
210201	Тэтгэврийн даатгал	12,007,600.00	44,902,097.38
210202	Тэтгэмжийн даатгал	1,264,000.00	4,774,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,011,100.00	3,819,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	252,900.00	954,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,528,000.00	9,548,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,560,217.00	13,129,698.71
210301	Гэрэл, цахилгаан	8,703,017.00	9,189,999.01
210302	Түлш, халаалт	3,580,700.00	3,698,599.70
210303	Цэвэр, бохир ус	276,500.00	241,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,025,450.00	24,283,270.00
210401	Бичиг хэрэг	5,627,770.00	4,452,300.00
210402	Тээвэр, шатахуун	29,910,400.00	15,301,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,216,280.00	3,487,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	864,000.00	711,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	407,000.00	330,000.00
2105	Нормативт зардал	7,366,130.00	22,233,290.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,770,530.00	21,655,690.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	595,600.00	577,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,792,190.00	5,131,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	604,300.00	300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,350,000.00	
210604	Урсгал засвар	3,837,890.00	4,831,000.00

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	19,967,960.00	17,838,400.00
210702	Дотоод албан томилолт	19,967,960.00	17,838,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,298,790,589.36	1,140,019,855.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,297,048,059.36	1,127,752,380.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	577,530.00	632,655.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	549,820.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	265,000.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		10,800,000.00
210807	Газрын төлбөр	-	142,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,792,792.00	987,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,792,792.00	987,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,537,920.64	28,646,479.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,057,500.00	27,635,501.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		26,839,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,057,500.00	796,001.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,480,420.64	1,010,978.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,480,420.64	1,010,978.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,160,000.00</u>	<u>13,700,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,160,000.00	13,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,160,000.00	13,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,160,000.00	13,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,160,000.00	13,700,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,160,000.00)</u>	<u>(13,700,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	906,939,600.00	905,956,631.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	906,939,600.00	905,956,631.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	879,254,100.00	878,321,130.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477,417,300.00	477,318,159.86
210101	Үндсэн цалин	376,765,800.00	391,696,702.75
210102	Нэмэгдэл	79,143,500.00	70,002,266.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,508,000.00	15,619,190.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,451,400.00	63,998,797.38
210201	Тэтгэврийн даатгал	45,354,700.00	44,902,097.38
210202	Тэтгэмжийн даатгал	4,774,200.00	4,774,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,819,300.00	3,819,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	954,900.00	954,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,548,300.00	9,548,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,129,700.00	13,129,698.71
210301	Гэрэл, цахилгаан	9,190,000.00	9,189,999.01
210302	Түлш, халаалт	3,698,600.00	3,698,599.70
210303	Цэвэр, бохир ус	241,100.00	241,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,428,200.00	18,427,200.00
210401	Бичиг хэрэг	4,452,300.00	4,452,300.00
210402	Тээвэр, шатахуун	9,445,600.00	9,445,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,487,700.00	3,487,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	711,600.00	711,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	331,000.00	330,000.00
2105	Нормативт зардал	4,225,500.00	4,225,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,647,900.00	3,647,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	577,600.00	577,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,884,200.00	6,879,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,104,300.00	2,100,000.00
210604	Урсгал засвар	4,779,900.00	4,779,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	4,964,400.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	4,964,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	288,809,400.00	288,469,275.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	276,203,700.00	276,201,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	632,700.00	632,655.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	731,000.00	549,820.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	142,000.00	142,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	908,400.00	908,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	908,400.00	908,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,685,500.00	27,635,501.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,685,500.00	27,635,501.00

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,839,500.00	26,839,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	846,000.00	796,001.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	906,939,600.00	905,928,631.95
1320	ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	906,939,600.00	905,928,631.95
122005	Төсвөөс санхүүжих	906,939,600.00	905,928,631.95
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	43.00	42.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	42.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	27.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	14.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,010,383,649.00	900,318,640.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,010,383,649.00	900,318,640.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,010,383,649.00	900,318,640.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,743,700.00	5,856,070.00
210402	Тээвэр, шатахуун	14,743,700.00	5,856,070.00
2105	Нормативт зардал	550,000.00	18,007,990.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	18,007,990.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	9,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	9,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	19,967,960.00	12,874,000.00
210702	Дотоод албан томилолт	-	12,874,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	905,724,997.00	853,950,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	905,724,997.00	853,950,580.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,396,992.00	130,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,396,992.00	130,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,010,383,649.00	900,318,650.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,010,383,649.00	900,318,650.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	121,469,489.00	34,502,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	888,914,160.00	865,816,550.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газар нь “Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 5,667.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 56.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 36.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Нийт үр дүнгийн зардал өмнөх оноос буурсан байгаа тул гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 3,175.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 31.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 65 хувиар буюу 20.6 сая төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **68,578.9** мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал		7,200.0	7,200.0
Бараа материал	174,647.9	162,094.1	-12,553.8
Үндсэн хөрөнгө	534,968.5	471,743.4	-63,225.1
Нийт хөрөнгө	709,616.4	641,037.5	-68,578.9
Богино хугацаат ер төлбөр	3,850.1		-3,850.1
Засгийн газрын оруулсан капитал	705,766.3	641,037.5	-64,728.8
Хуримтлагдсан үр дүн	661,815.0	597,086.2	-64,728.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,951.3	43,951.3	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	709,616.4	641,037.5	68,578.9

Бараа материалын дансны үлдэгдэл 162,094.1 мянган төгрөг болж 12,553.8 мянган төгрөгөөр буурсан нь шүлхий өвчний вакциныг МЭЕГ-т буцааж шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 471,743.4 мянган төгрөг болж 63,225.1 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс буурахад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын

газрын 471 дүгээр тогтоолоор 140 нэр төрлийн 380,324.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан нь гол нөлөөлжээ. Мөн тайлант онд бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй 31,200.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,850.1 төгрөгөөр буурч, өглөг бүрэн барагдсан байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 641,037.5 мянган төгрөг болж, 64,728.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

Мал эмнэлгийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,582,852.5 мянган төгрөг буюу 44.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй орлого, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь шүлхий өвчний вакцин өмнөх оноос буурч ирсэн мөн хэмжээгээр үйлчилгээний хөлс буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 2,431,788.0 мянган төгрөг буюу 42.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс эм, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 49,629.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 906,939.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 906,939.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 906,939.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 906,939.6 мянган төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлогоос 28.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 905,956.6 мянган төгрөгийг зарцуулж, 1,010.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 628,593.4 төгрөг буюу 99,7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 99,1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын төлөх шимтгэл 452.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 340.1 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 49.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөөс 34,502.1 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 865,816.6 мянга, нийт 900,318.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 5,856.1, норматив зардалд 18007.9, эд

хогшил, урсгал засварын зардал 9,500.0, томилолт, зочны зардалд 12,874.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 853,950.6, бараа үйлчилгээний бусад зардалд 130.0 нийт 900,318,6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Мал, эмнэлгийн газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал

Аудитын код: СБА-2022/30/НА-СТА-ТШЗ

хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 65.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 60.4 сая төгрөгийг залруулж, 5.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага

Малын гоц халдварт үхрийн арьс товруутах өвчний голомтод ажилласан ажиллагчдын томилолтын зардалд олгосон 5,440.0 мянган төгрөгийн ажил гүйлгээнд анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн хангаагүй зөрчил илэрлээ.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 99 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн		Албан		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газар	3	5.4	1	60.4	-	-	1	5.4	1	-